

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ЦАХИМ ХӨГЖИЛ,
ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 04 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/130 А/58

Улаанбаатар
хот

“Журам шаардлага шинэчлэн батлах тухай”

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газар /П.Оюунцэцэг/, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга /Б.Бат-Өлзий/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар /О.Энхболд/-т, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбарын хяналтын газар /С.Цагаанхүү/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын хамтарсан “Журам, шаардлага батлах тухай” 2024 оны А/138, А/37 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД





Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2025 оны 04 сарын 16 -ны өдрийн 4/159/А.1/28 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ашиглагдах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж нь дараах ерөнхий болон модулийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Бүлэг	Д / Д	Шаардлага	Заавал хангасан байх
Нэг. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА				
1.1.	Зохиогчийн эрх	1.	Программ хангамж, өгөгдлийн сан болон ашиглаж буй бүрэлдэхүүн хэсгүүд нь оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй байх	+
1.2.	Хэрэглэгч	2.	Хэрэглэгчийн хандах эрхийн удирдлагатай байх (хэрэглэгч тус бүрээр үйлдлийг тохируулдаг байх)	+
		3.	Хэрэглэгчийн нэвтрэх нэр эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн кодтой уялдсан байх	+
		4.	Нууцад хамаарах мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах эрхийг тусгайлан тохируулдаг байх (Эрүүл мэндийн салбарын албаны нууц батлах тухай тушаалыг дагаж мөрдөнө. Жишээ нь: “ДОХ”-ын шинжилгээний хариу гэх мэт)	+
		5.	Хэрэглэгч нууц үгээ мартсан тохиолдолд админы дэмжлэггүйгээр сэргээх боломжтой байх	+
		6.	Үйлчлүүлэгчийн бүртгэл үүсгэх, шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем /ХУР/-ээс татдаг байх	+
		7.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс бусад зорилгоор хүний хувийн мэдээлэлд хандахад (цуглуулах, боловсруулах, ашиглах)-даа мэдээллийн эзнээс, мөн мэдээллийн эзэн зөвшөөрөл өгөх чадамжгүй тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс “Зөвшөөрөл” авах боломжийг бүрдүүлсэн байх	+
1.3.	Программ хангамжийн ажиллагаа ба UI/UX	8.	Үйлчлүүлэгчийн мэдээлэлд хандсан үед “Мэдэгдэл” хүргэдэг байх	+
		9.	Программ хангамжийн хөгжүүлэлтийн орчин буюу туршилтын орчныг бүрдүүлсэн байх	+
		10.	Эрх бүхий байгууллагаас тогтоосон цагийн улсын эталоныг ашигласан байх	+
		11.	Программ хангамжийн “интерфэйс” нь монгол хэл дээр байх	+
		12.	Цахим гарын үсгийг дэмждэг байх	+
		13.	Мэдээллийг хугацааны интервал (өгөгдсөн хугацааны хооронд)-аар хайдаг байх	+
		14.	Хэрэглэгчийн тодорхойлсон бүх төрлийн	+

			талбарын утгаар хайлт хийдэг байх (Жишээ нь: үйлчлүүлэгчээр, өвчнөөр, оношоор, эмчээр гэх мэт)	
		15.	Администратор нь программ хангамжийн бүтцийн тохиргоог боломжит түвшинд удирддаг байх (мэдээллийн төрөл, бүлэг, байгууллага, байгууллагын төрөл, салбарын бүлэг, тайлангийн тохиргоо гэх мэт)	+
		16.	Мэдээллийг хууль, журамд заасан хугацаагаар нөөцөлдөг байх (Backup)	+
		17.	Программ хангамжийн тохиргооны болон суурилуулалт, хэрэглэгчийн гарын авлагатай байх	+
		18.	Үйлчилгээний нөхцөлийг тодорхойлсон байх	+
		19.	Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-тэй холбогдсон байх (мэдээлэл нийлүүлэх, хүлээн авах)	+
		20.	Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны системтэй стандартын дагуу холбогдсон байх (мэдээлэл нийлүүлэх, хүлээн авах)	+
		21.	Сервисийн оролт, гаралтыг тодорхойлсон бичиг баримттай байх	+
1.4.	Мэдээллийн ангилал, код, тайлбар, кодчилол	22.	Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, боловсруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.10-т заасан нэгдсэн ангилал, код, тайлбар болон олон улсын стандарт, кодчилол (ICD, FHIR/HL7, SNOMED CT, LOINC)-ыг дагаж мөрдсөн байх	+
1.5.		23.	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн мэдээллийн сангаас татах боломжтой байх	+
1.6.		24.	Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн кодчиллыг эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сангаас татах боломжтой байх	+
1.7.	Аюулгүй байдал	25.	Программ хангамжид кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх	+
		26.	Программ хангамжид мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн байх	+
1.8.	Тайлан	27.	Батлагдсан маягтын дагуу тайлан, мэдээг гаргадаг байх	+
		28.	Тайлан, мэдээллийг XLS, TXT гм олон төрлийн файлын форматаар татан авах, хэвлэх боломжтой байх	+
		29.	Мэдээллийн сангаас гарах мэдээлэлд эх сурвалжийг тогтоох тэмдэглэгээтэй байх (ямар байгууллагын аль мэдээллийн сангаас мэдээлэл татагдсан талаарх тэмдэглэгээ, хугацааны хамт)	+
		30.	Тусламж, үйлчилгээний төрлөөр өртөг, зардлыг тооцоолох боломжтой байх (үйлчлүүлэгч эмнэлгээс гарах зардлыг тооцоолох гэх мэт)	+
ХОЁР МОДУЛИЙН ШААРДЛАГА				
2.1.	Хэвтэн эмчлүүлэгчийн бүртгэл	31.	Өвчний түүх болон тусламж, үйлчилгээний бүртгэлийн дугаарыг давхардуулахгүй үүсгэдэг байх	+

	(стационар и)	32.	Өвчний түүх болон тусламж, үйлчилгээний бүртгэлийн дугаарыг тогтоосон хугацаанаас эхлэн мэдээллийг шинээр тоолох боломжтой байх (Жишээ нь: 1 сарын 1-ээс гэх мэт)	+
		33.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл бүрээр мэдээллийг иж бүрэн бүртгэх, харах, хайх боломжтой байх (өвчний түүх, сувилгааны түүх гэх мэт)	+
		34.	Тасаг, кабинет, ерөө хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлдэг байх	+
2.2.	Сувилахуй	35.	Сувилгааны түүхийг иж бүрэн хөтлөх, харах, хайх боломжтой байх	+
2.3.	Дүрс оношилгоо	36.	Дүрс оношилгооны тоног төхөөрөмжтэй холбогдон ажилладаг байх	+
		37.	Дүрс оношилгооны мэдээллийг автоматаар хадгалах боломжтой байх (PACS)	+
		38.	Дүрс оношилгооны төрөл бүрд тохирсон дүгнэлт бичих батлагдсан маягтыг нэвтрүүлсэн байх (цээжний рентген, гар сарвууны рентген, хэвлийн ЭХО, бамбайн ЭХО, СТ, MRI гэх мэт)	+
		39.	Дүрс оношилгооны тохиргоог удирдах боломжтой боломжтой байх (тоног төхөөрөмж, ашиглалт, тайлан мэдээ гэх мэт)	+
2.4.	Лаборатори	40.	Лабораторийн тоног, төхөөрөмжтэй холбогдон ажиллаж, хариуг автоматаар татдаг байх	+
		41.	Тухайн лабораторийн тоног, төхөөрөмжийн лавлах хэмжээтэй харгалзуулан шинжилгээний хариуг татаж авдаг байх	+
		42.	Шинжилгээний төрөл бүрд тохирсон хариу бичих батлагдсан маягтыг нэвтрүүлсэн байх (Биохимийн шинжилгээ, шээсний шинжилгээ гэх мэт)	+
		43.	Лабораторийн тохиргоог удирдах боломжтой байх (тоног төхөөрөмж, лавлах хэмжээ, ашиглалт, тайлан мэдээ гэх мэт)	+
2.5.	Цахим бүртгэл	44.	Тусламж, үйлчилгээний хуваарийг удирдах боломжтой байх (эмчийн үзлэгийн цаг товлох, өөрчлөх, цуцлах гэх мэт)	+
		45.	Тусламж, үйлчилгээний сул цагийг харуулах боломжтой байх	+
		46.	Эрүүл мэндийн даатгал төлөгдсөн эсэхийг шалгадаг байх	+
		47.	Тусламж, үйлчилгээ үзүүлсэн баримтыг олгодог байх	+
		48.	Тухайн үйлчлүүлэгчийн захиалгын давхардлыг шалгах боломжтой байх	+
		49.	Тухайн үйлчлүүлэгчийн өмнө авсан үйлчилгээний мэдээллийг харах боломжтой байх	+
		50.	Эрүүл мэндийн лавлагаа, тодорхойлолтыг	+

			бүртгэх, харах, хайх боломжтой байх	
		51.	Тусламж, үйлчилгээний хөнгөлөлт оруулах боломжтой байх (анхан шатлалаас бусад)	+
		52.	Цахим бүртгэлийн мэдээг төрөл бүрээр боловсруулдаг байх	+
		53.	Эмнэлгийн кассын ажиллагаатай холбогдон ажилладаг байх (анхан шатлалаас бусад)	+
2.6.	Яаралтай тусламж	54.	Яаралтай тусламжийн үзлэгийн хуваарийг удирдах боломжтой байх (бүртгэх, өөрчлөх, цуцлах гэх мэт)	+
		55.	Яаралтай тусламж үзүүлсэн тухай мэдээллийг бүртгэх, хайх, харах, мэдээлэх боломжтой байх	+
		56.	Яаралтай тусламжийн эрэмбэлэн ялгалтыг тэмдэглэх боломжтой байх	+
2.7.	Амбулатори	57.	Үйлчлүүлэгч рүү эрүүл мэндийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэдэг байх	+
		58.	Шаардлагатай асуумж, судалгаа авах боломжтой байх	+
		59.	Эрүүл мэндийн хичээл үзэх боломжтой байх	+
		60.	Эрүүл мэндийг үнэлэх боломжтой байх	+
		61.	Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр ажиллах цагийг тохируулан, удирдах боломжтой байх	+
		62.	Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр нормыг тохируулан, удирдах боломжтой байх	+
2.8.	Эрүүл мэндийн даатгал, санхүү	63.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл бүрээр төлбөрийн мэдээллийг тохируулан удирдах боломжтой байх (эрүүл мэндийн даатгалын төлбөр, төлбөрт үйлчилгээ гэх мэт)	+
		64.	Эмнэлгийн нөөцийн мэдээллийн тохиргоог удирддаг байх (хүний нөөц, эмнэлгийн ор, кабинет, эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэт)	+
2.9.	Эм, эмнэлгийн хэрэгсэл	65.	Үйлдвэрлэлийн цувралын дугаарыг харуулдаг байх	+
		66.	Барааны баркодоор бүртгэж, хайдаг байх	+
		67.	Тухайн оношинд хамаарах эмийн мэдээллийг лавлан, дууддаг байх	+
		68.	Эмийг олон улсын нэршлээр хайдаг байх	+
		69.	Холимог найрлагатай болон уламжлалтын эмийг худалдааны нэршлээр хайдаг байх	+
		70.	ОУ-ын нэршил болон худалдааны нэршлийн аль нэгнээр хайхыг заасан хялбар тэмдэглэгээтэй байх	+
		71.	Эмийн жорын түүхийг жорын дугаараар лавлаж, харах боломжтой байх	+
		72.	Эмийн жорын түүхийг үйлчлүүлэгчийн регистрийн дугаараар лавлаж, харах боломжтой байх	+
		73.	Тодорхой эм ууж буй үйлчлүүлэгчдийг хайх	+

			боломжтой байх	
		74.	Үйлчлүүлэгч дурын жилээр жорын түүхийг харах боломжтой байх	+
		75.	Эмийн жор бичилтийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй MNS стандартын дагуу бүртгэх, хэвлэх, илгээдэг байх	+
		76.	Эмийн гаж нөлөөг бүртгэж, илгээдэг байх	+
		77.	Сэтгэцэд нөлөөт болон мансууруулах эмийн жорыг бүртгэхэд эрх олгогдсон эмчийн албан тушаалтай холбосон байх	+
		78.	Эмчид бичсэн жорыг мөрдсөн эсэхийг харуулдаг байх (худалдан авсан болон бичсэн жорын мэдээлэл нэг дор харагддаг байх)	+
		79.	Эмийн харилцан үйлчлэл, эмийн харшлыг шалгах, сэрэмжлүүлэх боломжтой байх	+
2.10	Эрүүл мэндийн цахим карт		Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-ээр холбогдох боломжтой байх	+
			Үйлчлүүлэгч өөрийн үйлчилгээ авсан түүхийг дэлгэрэнгүй харах боломжтой байх	+
2.11	Эмнэлэгт үйлчлүүлэгч илгээх, хүлээн авах			+
2.12	"Телемедицин" харилцаа холбооны болон цахим технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зайнаас үзүүлэх			+

Гурав. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛД ХАМААРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ШААРДЛАГЫН ХҮСНЭГТ

Тухайн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч дараах модулийг иж бүрдлээр болон хэсэгчлэн авч ашиглаж болох ба нэмэлт модуль, функцийг хөгжүүлэн, нэвтрүүлж, ашиглахыг хориглоогүй болно.

№	МОДУЛИЙН НЭР	Өрхийн эмнэлэг	Сум, тосгоны эмнэлэг	Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, амаржих газар, тусгай эмнэлэг, клиник эмнэлэг	Сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сэргээн засах төв	Тусгай мэргэжлийн төв	Түргэн тусламжийн төв	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах байгууллага	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага (лаборатори)	Нийтийн эрүүл мэндийн төв
3.1.	Ерөнхий шаардлага	+	+	+	+	+	+	+	+	+
3.2.	Цахим бүртгэл	+	+	+	+	+	+	+	+	+
3.3.	Удирдлагын хяналт, статистик, тайлан, мэдээ	+	+	+	+	+	+	+	+	+
3.4.	Амбулатори	+	+	+	+	+	+	+	+	+
3.5.	Хэвтэн эмчлүүлэгчийн бүртгэл (стационари)		+	+	+					
3.6.	Яаралтай тусламж	+	+	+	+	+	+	+	+	+
3.7.	Сувилахуй	+	+	+	+	+	+	+	+	+
3.8.	Лаборатори	+	+	+	+	+	+	+	+	+
3.9.	Дүрс оношилгоо	+	+	+	+	+	+	+	+	+
3.10.	Эм, эмнэлгийн хэрэгсэл	+	+	+	+	+	+	+	+	+
3.11.	Эрүүл мэндийн даатгал, санхүү	+	+	+	+	+	+	+	+	+
3.12.	Эрүүл мэндийн цахим карт	+	+	+	+	+	+	+	+	+
3.13.	Эмнэлэгт үйлчлүүлэгч илгээх, хүлээн авах	+	+	+	+					
3.14.	Телемедицин	+	+	+	+		+			+

Эрүүл мэндийн сайд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2025 оны 09 сарын 16-ны өдрийн А/152/ А/52 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД
ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ
МЭДЭЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн тухай хуулийн 8.10-т заасан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж /цаашид "программ хангамж" гэх/-д үнэлгээ хийж, шаардлагад нийцсэн программ хангамжийг олон нийтэд мэдээлэх харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
түүний зохион байгуулалт**

2.1. Эрүүл мэндийн сайд болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан байнгын ажиллагаатай Ажлын хэсэг программ хангамжид үнэлгээ хийж, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Ажлын хэсэг дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

2.2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-1;

2.2.2. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-1;

2.2.3. Тагнуулын ерөнхий газрын Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв-1;

2.2.4. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-1;

2.2.5. Эрүүл мэндийн хөгжлийн төв-1;

2.2.6. И-Монгол академи УТҮГ-ын төлөөлөл -1;

2.2.7. Үндэсний Дата Төв УТҮГ-ын төлөөлөл-1;

2.2.8. Эрүүл мэндийн салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл-1;

2.2.9. Мэдээллийн технологийн салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл-1

2.3. Энэ журмын 2.2.8, 2.2.9-д заасан гишүүнийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэж томилно.

2.4. Ажлын хэсгийн үйл ажиллагаа хурал хэлбэртэй байна. Ажлын хэсгийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл даргална.

2.5 Ажлын хэсгийн хурлын шийдвэрийг тэмдэглэлээр баталгаажуулна. Ажлын хэсэг нь дүгнэлт, зөвлөмж гаргана.

2.6. Ажлын хэсгийн нарийн бичгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс томилох

бөгөөд нарийн бичиг нь хурлын тэмдэглэлийг хөтөлж, хуралд саналын эрхгүй оролцоно.

2.7. Хурлын дэгийг хууль, журамд заасан нийтлэг зохицуулалтын дагуу боловсруулж, хурлаар хэлэлцэн батална.

2.8. Ажлын хэсгийн хуралд тухайн хүсэлт гаргасан программ хангамж хөгжүүлэгчийн төлөөлөл оролцоно.

2.9. Ажлын хэсгийн хурал нь 7 ба түүнээс дээш гишүүдийн ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдох ба хурлыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулна.

2.10. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.11. Энэ журмын 2.5-д заасан шийдвэрийг ажлын хэсгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12. Ажлын хэсгийн хуралд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн болон холбогдох бусад салбарын мэргэжлийн зөвлөл, мэргэжлийн холбоодын төлөөлөл, шинжээчийг саналын эрхгүйгээр оролцуулж болно.

2.13. Ажлын хэсгийн гишүүн программ хангамжаа үнэлүүлэх хүсэлт ирүүлсэн байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий этгээд байх тохиолдолд хурлын даргад мэдэгдэж, тухайн хуралд оролцохгүй.

2.14. Программ хангамжийн үнэлгээтэй холбоотой санал, гомдлыг ажлын хэсгийн нарийн бичиг хүлээн авч, ажлын 10 өдрийн дотор тус асуудлыг дахин ажлын хэсгээр хэлэлцүүлнэ.

2.15 Ажлын хэсгийн гишүүдийн томилолтын зардал болон мөнгөн урамшууллыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хууль журамд нийцүүлэн олгож болно.

Гурав. Программ хангамжид үнэлгээ хийх, мэдээлэх

3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж хөгжүүлэгч нь хөгжүүлсэн программ хангамжаа үнэлүүлэх тухай хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаасаар, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ:

3.1.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.1.2. байгууллагын танилцуулга, туршлага, хүний нөөцийн мэдээлэл;

3.1.3. программ хангамжийн модулийн жагсаалт, ашиглаж буй технологийн танилцуулга;

3.1.4. үйлдлийн систем, тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга;

3.1.5. мэдээллийн сүлжээ болон программ хангамжийн бүтэц схем;

3.1.6. программ хангамжид ашиглагдаж буй гуравдагч талын сервис ашиглах

бол тэдгээрийн жагсаалт;

3.1.7. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас тухайн программ хангамжид хийсэн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;

3.1.8. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан шаардлагыг хангаж байгаа талаарх нотлох баримтыг тайлбарын хамт ирүүлэх;

3.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн бүрдүүлбэрийн шаардлага хангасан эсэхийг ажлын 3 хоногт багтаан хянаж, бүрдүүлбэр хангасан бол ажлын хэсэгт болон хүсэлт гаргагч этгээдэд, бүрдүүлбэр хангаагүй бол хүсэлт гаргагч этгээдэд бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

3.3. Ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан энэ тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан холбогдох шаардлагын дагуу программ хангамжид үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

3.4. Шаардлага хангасан программ хангамжийн талаарх мэдээллийг нарийн бичиг Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсаар мэдээлнэ.

3.5. Ажлын хэсэг шаардлага хангаагүй буюу хангалтгүй үнэлэгдсэн тухай шийдвэрийг энэ журмын 3.1-д заасан хүсэлт гаргагчид ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

3.6. Ажлын хэсэг программ хангамж, шаардлага өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлтөд хамааралтай хэсэгт хэсэгчлэн дүгнэлт гаргаж болно.

3.7. Дүгнэлт гарсан программ хангамжид өөрчлөлт, шинэчлэлт орсон, шинэ модуль, функц нэмэгдсэн тохиолдолд систем хөгжүүлэгч нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдэгдэж, тус төв дахин дүгнэлт гаргуулах эсэхийг ажлын хэсгээр шийдвэрлүүлнэ.

3.8. Тус журмын хавсралтаар заасан шаардлага шинэчлэгдсэн бол өмнө дүгнэсэн программ хангамжуудыг Эрүүл мэндийн хөгжлийн төв нягтлан үзэж, холбогдох өөрчлөлтөд тохирох хэсэгт дахин дүгнэлт гаргуулах эсэхийг тогтооно.

3.9. Тус журмын хавсралтаар заасан эрүүл мэндийн программ хангамжид тавигдах шаардлага, эрүүл мэндийн байгууллагын төрөл, модуль зэргийг хууль тогтоомж, технологийн хөгжилд нийцүүлэн тухай бүр Эрүүл мэндийн хөгжлийн төв өөрчлөх саналыг боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.